

ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХ ЯВЦАД ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ:

ENSURING THE SECURITY OF DECISION EXECUTORS IN THE PROCESS OF ENFORCEMENT OF CIVIL DECISIONS:



Г.Түвшинтөр

Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар

нээлттэй, хаалттай хорих ангийн ахлах төлөөлөгч, ахмад

Товч утга: Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийг хангахын тулд зайлшгүй төрийн албадлагын ажиллагаа хийх шаардлага гардаг бөгөөд энэ ажиллагааны бие даасан нэг төрөл нь иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ юм. Энэхүү ажиллагааг хэрэгжүүлж байгаа эрх зүйн субъект нь шийдвэр гүйцэтгэгч бөгөөд тэдний аюулгүй байдлыг хангах асуудал орхигдсоор байна. Энэхүү судалгааны ажлаар иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах явцад шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангах арга замын талаар авч үзлээ.

Түлхүүр үгс: Шийдвэр гүйцэтгэгч, төрийн албадлага, иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах, аюулгүй байдал, хангах арга зам

Abstract: In order to ensure the execution of the court decision, there is a need for mandatory state coercive action, and one of the independent types of this action is the civil enforcement action. The legal entity implementing this operation is the decision maker, and the issue of ensuring their safety is still neglected. In this research work, the way to ensure the safety of the decision maker during the verification of the execution of the civil decision has been considered.

Keywords: Decision maker, state coercion, civil enforcement, security and enforcement.

Хүн өдөр тутамдаа нийгмийн харилцаа, тэр тусмаа эрх зүйн харилцаанд орж байдаг бөгөөд энэ явцад эрх, эрх чөлөө зөрчигдөх, хохирох асуудал үүсч, эрхээ хамгаалуулахаар хууль, шүүхийн байгууллагад хандаж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэдэг билээ. Энэ процесс ажиллагааны үр дүн нь шүүхийн шийдвэрээр эцэслэгдэж, тэр нь нэг мөр биелэгдснээр хүн эрх, эрх чөлөө сэргээн, улмаар хуулийн байгууллагад иргэдийн итгэх илтгэл бий болно.

Энэ утгаараа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага бол олон шат дамжлагатай хуулийн байгууллагуудын хийсэн ажлын үр дүнг гүйцэтгэлээрээ тодорхойлдог төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага юм. Харин үүнийг хэрэгжүүлж байгаа эрх зүйн субъектын нэг бол шийдвэр гүйцэтгэгч бөгөөд тэдгээрийн эдлэх эрх, хүлээх үүргийг хуулиар баталгаажуулж өгсөн ч, тэдний ажил үүргийн онцлогтой холбоотойгоор бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад нь аюулгүй байдлыг давхар өндөр түвшинд хангаж байх нь гүйцэтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх чухал ойлголт юм.

Тэгэхээр шийдвэр гүйцэтгэгчийн чиг үүрэг, ажлын онцлогтой холбоотойгоор тэдний аюулгүй байдлыг авч үзэх асуудал нь нэг талаар эрх зүйн суурь шинжтэй ойлголт юм. Өөрөөр хэлбэл үйл ажиллагаа, чиг үүрэг, бүрэн эрхээ тодорхой тогтсон байранд хэрэгжүүлдэг Шүүх, Прокурорын байгууллагын алба хаагчдаас өөр гэсэн үг юм. Шийдвэр гүйцэтгэгч нь бүрэн эрхээ албан өрөөндөө хэрэгжүүлэхээс илүүтэйгээр гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөр төлөгч этгээдүүдийг орон байр, эд хөрөнгө байгаа газар явуулдаг онцлогтой юм.

Иймд тэдний тухайн нөхцөл дэх аюулгүй байдлыг хангах нь хамгийн чухал асуудал бөгөөд эрх зүйн онолын хувьд аюулгүй байдлыг урьдчилан хангах ойлголт юм.

Хэдийгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар аюулгүй байдлыг хангах хариуцлагын төрлүүдийг зааж өгсөн боловч энэ бол аюулгүй байдлын дараагийн түвшний ойлголт.

Иймд энэхүү судалгааны ажлаар шийдвэр гүйцэтгэгчийн ажил, чиг үүргийн онцлогтой холбоотойгоор бүрэн эрхээ хэрэгжүүлэх / цаашид иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах явцад гэх / явцад аюулгүй байдлыг нь урьдчилан хангах арга замын талаар тодорхойлон авч үзлээ.

Нэг. Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах тухай ойлголт, түүний төрлүүд

Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах гэдэг бол нэр томъёоны хувьд шинэ ойлголт юм. “Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ гэж гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг албадан гүйцэтгэх, эсхүл төлбөр төлөгчийг гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн шийдвэр гүйцэтгэгчийн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг ойлгоно”⁷⁹ Үүнд:

⁷⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг. Төрийн мэдээлэл - 2017 он. №24

- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдийн төлөөллийг дуудан ирүүлэх;
- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдээс гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэхэд шаардлагатай баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулан авах;
- Төлбөр төлөгч болон бусад этгээдээс төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулан авах, түүнийг төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэх;
- Төлбөр төлөгчийн үйл ажиллагаанд холбогдох санхүүгийн болон бусад баримт бичигт үзлэг хийх;
- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдэд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах зорилгоор тодорхой үүрэг хүлээлгэх, энэ тухай мэдэгдэл хүргүүлэх;
- Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн орон байрнаас бусад газар, барилга байгууламж, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, үзлэг хийх;
- Төлбөр төлөгчийг албадан нүүлгэхээс бусад тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрснөөр төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн орон байранд нэвтрэн орох, үзлэг хийх.
- Гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэх зорилгоор төлбөр төлөгчийн бие, бэлэн мөнгө, бусад хөрөнгөд үзлэг хийх, тэдгээрийг битүүмжлэх, барьцаалах, хураан авах, худалдан борлуулах, хураан авсан эд зүйл, хөрөнгийг хадгалуулах, хамгаалуулахаар хүлээлгэн өгөх;
- Хуульд заасан үндэслэл, журмын дагуу битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан эд зүйл, хөрөнгийг үнэлэх, уг ажиллагаанд шинжээчийг оролцуулах;
- Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах;
- Төлбөр төлөгчийн эд хөрөнгө, түүний эрхийн бүртгэлийн талаар улсын бүртгэлийн байгууллагад хандах, лавлагаа, тодорхойлолт гаргуулах;
- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогчоос гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;Төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах дансан дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, эсхүл эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих;
- Төлбөр төлөгчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эрхийг түдгэлзүүлэх;
- Үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх;

- Худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөрт тооцон суутгаж төлбөр авагчид шилжүүлэх, уг зорилгоор албадан чөлөөлөх;
- Хуульд заасан бусад.

Өөрөөр хэлбэл Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ гэдэг бол шийдвэр гүйцэтгэгчийн хуулиар олгогдсон бүрэн эрхтэй шууд холбогдох ойлголт бөгөөд бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэж ойлгож болно.

Гурав. Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлын тухай ойлголт ба өнөөгийн байдал

3.1. Аюулгүй байдлын тухай ойлголт:

Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдал гэх ухагдахууныг авч үзэхийн өмнө ер нь “Аюулгүй байдал” гэж юуг ойлгоод байгаа талаар товч үзье.

Түүхийн цаг хугацааны үе шат бүрт “Аюулгүй байдал” гэх ойлголтыг бүхий л салбарын эрдэмтэн судлаач, философичид хүний буюу хүн төрөлхтний хэвийн аж төрөх, оршин тогтнох, хөгжин дэвших амьдралын зорилго, үйл ажиллагаатай холбож авч үзжээ.⁸⁰

Аюулгүй байдлын тухай ойлголтыг хэл зүйн талаас нь судлахад: Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” бүтээлд “аюулгүй: - аймаар, жигшмээр юмгүй, аюултай: байвал зохих” хэмээн тайлбарлажээ.⁸¹ Харин Б.Баярсайхан “Монгол хэлний тайлбар толь” эмхэтгэлд “Аюулгүй: - аюулгүй байхгүй, айж эмээх, сандрах түгшүүргүй” хэмээн тайлбарлажээ.⁸²

Энэ бүгдээс дүгнэхэд “аюулгүй байдал “хэмээх ойлголт нь хүн, төр, нийгмийн амин чухал хэрэгцээ хангагдсан байдал гэсэн ойлголтоор илрэн гарч байна.

Тэгэхээр аюулгүй байдал гэх ойлголт нь маш өргөн утга, агуулга бүхий ойлголт болох нь харагдаж байх бөгөөд үүнээс шийдвэр гүйцэтгэгч гэсэн эрх зүйн сүбъект хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад аюулгүй байдал нь хэрхэн хангагдаж байгаа талаар тусгайлан авч судлах нь зүйтэй гэж үзлээ.

3.2. Шийдвэр гүйцэтгэгч, түүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад аюулгүй байдлыг нь хэрхэн хангах буй талаарх эрх зүйн зохицуулалт:

Шийдвэр гүйцэтгэгч гэж Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, ёс зүйн шаардлага, шалгуур

⁸⁰ Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдал. УБ., 2017 он. 12 дахь тал.

⁸¹ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 2007 он. 5 дахь тал.

⁸² Б.Баярсайхан. Монгол хэлний тайлбар толь. УБ., 2011 он. 87 дахь тал.

үзүүлэлтийг хангасан, арван найман насанд хүрсэн, дээд боловсролтой, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн Монгол Улсын иргэн⁸³ байна.

Шийдвэр гүйцэтгэгч нь ерөнхий шийдвэр гүйцэтгэгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчээс бүрдэнэ.⁸⁴ гэж заажээ.

Дээрх эрх зүйн субъектийн аюулгүй байдлыг холбогдох хууль тогтоомжоор хэрхэн тодорхойлсон байдлыг авч үзье.

Монгол улсын Зөрчлийн тухай хуульд: Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах гэж юуг ойлгох, тэдгээрт хүлээлгэх хариуцлагыг заажээ. Үүнд:

1. Төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан;
2. Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд нь саад учруулсан;
3. Төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.⁸⁵ / *Тайлбар: “хууль сахиулах чиг үүрэг” шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчийн хуульд заасан чиг үүргийг ойлгоно гэж тодорхойлсон /*

-Монгол улсын Эрүүгийн хуульд: Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэдгийг хэрхэн ойлгох талаар тодорхойлж, хүлээлгэх хариуцлагыг мөн заажээ. Үүнд: Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ гэмт хэргийг галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, хууль сахиулах албаны тоног төхөөрөмж, барилга, байгууламжид халдаж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.⁸⁶ гэж тус тус,

⁸³ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 270 дугаар зүйлийн 270.3 дахь хэсэг. Төрийн мэдээлэл - 2017 он. №24

⁸⁴ МУ-ын “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 270 дугаар зүйлийн 270.2 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2017 он. №24

⁸⁵ МУ-ын “Зөрчлийн тухай хууль”-ийн 15.2 дугаар зүйлийн 2-ийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2017 он. №24

⁸⁶ МУ-ын “Эрүүгийн хууль”-ийн 23.1 дүгээр зүйлийн 2-ийн 2.1, 2.2 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2016 он. №7

- Мөн хуульд Нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэж нийтийн албан тушаалтныг тодорхой шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахгүй байх, үйл ажиллагаа явуулахгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотны хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.⁸⁷ гэж тус тус заажээ.

Хэдийгээр шийдвэр гүйцэтгэгч нь нийтийн албан тушаалтан, хууль сахиулагч болохын хувьд аюулгүй байдалд нь дээрх байдлаар халдсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой заасан сайн тал боловч, дээрх зөрчил, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудал нь хамгийн чухал юм. Үүнийг холбогдох хуульд хэрхэн тодорхойлсон талаар авч үзье.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болно.⁸⁸

1. Биеийн хүчийг дараах тохиолдолд хэрэглэнэ.

- Алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн.

- Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад албадан хүргэх үед эсэргүүцэл үзүүлсэн;

- Нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхээр энэ хуульд заасан тохиолдолд.

2. Нэг бүрийн тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ.⁸⁹

- Өөрийн, бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй аюулыг таслан зогсоох;

- Зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй ялтан, хоригдлыг баривчлах;

- Хоригдол хорих ангийн алба хаагчийн тавьсан шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцсэн;

- Алба хаагчийн аюулгүйн тойрогт зөвшөөрөлгүй нэвтэрсэн;

- Хоригдлыг хуяглан хүргэх;

⁸⁷ МУ-ын “Эрүүгийн хууль”-ийн 23.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2016 он. №7

⁸⁸ МУ-ын “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 290 дүгээр зүйлийн 290.1 дэхь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2017 он. №24

⁸⁹ МУ-ын “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 292 дугаар зүйлийн 292.1 дэхь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2017 он. №24

- Хяналтад байгаа хоригдол амиа хорлох, өөрийн бие махбодод гэмтэл учруулах, оргон зайлж болзошгүй бол тэдгээрээс урьдчилан сэргийлэх;

- Хорих байгууллага дотор гарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хяналтдаа авах, хорих байгууллага доторх аливаа хууль бус үйлдлийг таслан зогсоох, хорих байгууллагыг бүслэн хаасныг чөлөөлөх;

- Хуульд галт зэвсэг хэрэглэхээр заасан бусад.

3.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ:⁹⁰

- Хорих ангид бүлэглэн халдсан;

- Хорих ангийн дотоод журмыг бүлэглэн зөрчсөн, эсхүл хорих ангид гарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох.


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч дээрх тохиолдлуудад биеийн хүч, тусгай хэрэгсэл, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэж, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангахаар заасныг нэг бүрчлэн анзаарвал:

Дээрх тохиолдлууд бол Хорих байгууллагын алба хаагч руу чиглэсэн хамгаалалт байгаа нь тодорхой байна. Тэгвэл шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрх, чиг үүрэгтэй холбогдуулан, тухайлбал: шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгөнд үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, хураах ажиллагаа явуулж байх тохиолдолд биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрхэн хэрэглэх талаарх тохиолдлууд нь ойлгомжгүй бөгөөд нарийн тодорхой заагаагүй байна.

3.3. Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлын судалгаа:

Шийдвэр гүйцэтгэгч нарыг албан үүргээ буюу бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан халдсан, заналхийлсэн тохиолдлуудыг 2014, 2015, 2016, 2017 онуудын байдлаар авч үзье. / Зураг -1 /

⁹⁰ МУ-ын “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 295 дугаар зүйлийн 295.1 дэхь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2017 он. №24



Дээрх судалгаанаас харахад жил ирэх тусам шийдвэр гүйцэтгэгч ямар нэгэн халдлагад өртөх нь нэмэгдэж байх бөгөөд 2013 онд нэг шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах явцад төлбөр төлөгчөөс эсэргүүцэл үзүүлж, буудуулж амь насаа алдсан тохиолдол ч байгаа гэдгийг сануулах нь зүйтэй.

Дөрөв. Дүгнэлт

1. Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангахдаа зөрчил, гэмт хэрэг гарсан тохиолдолд л хүлээлгэх хариуцлагыг заасан байх бөгөөд аюулгүй байдлыг хангах урьдчилсан хамгаалалтын талаар эрх зүйн зохицуулалт бараг байхгүй байна.

2. Шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад аюулгүй байдлыг нь хэрхэн хамгаалах эрх зүйн зохицуулалтыг хорих байгууллагын алба хаагчаас тусгайлан авч үзэх.

Санал:

1. Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангахдаа зөрчил, гэмт хэрэг гарсан тохиолдолд л хүлээлгэх хариуцлагыг заасан байх бөгөөд аюулгүй байдлыг хангах урьдчилсан хамгаалалтын талаар эрх зүйн зохицуулалтыг хуулиар бий болгох.

2. Шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад аюулгүй байдлыг нь хэрхэн хамгаалах эрх зүйн зохицуулалтыг хорих байгууллагын алба хаагчаас тусгайлан авч үзэж, тодорхой зааж өгөх.

3. Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангах тусгай нэгж / алба хаагч /-ийг алба бүр дээр байгуулж, иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах явцад аюулгүй байдлыг нь хангуулах.

4. Шийдвэр гүйцэтгэгч бүрийг тусгай хэрэгслээр хангах, сургалт, бэлтгэл тогтмол зохион байгуулах эрх зүйн үндэслэлийг бий болгох гэсэн саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол Улсын “Эрүүгийн хууль”, Төрийн мэдээлэл эмхэтгэл., 2016 он. №7
2. Монгол Улсын “ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”, Төрийн мэдээлэл., 2017 он. №24
3. Монгол Улсын “Зөрчлийн тухай хууль”, Төрийн мэдээлэл эмхэтгэл - 2017 он. №24
4. Баярсайхан, Б., Монгол хэлний тайлбар толь. УБ., 2011 он.
5. Очгэрэл, Ц., Хорих байгууллагын аюулгүй байдал. УБ., 2017 он.
6. Цэвэл, Я., Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 2007 он.
7. Хууль сахиулахын их сургууль., Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын менежментэд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам онол, практикийн хурлын эмхэтгэл. УБ., 2015 он.

---o0o---